

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЕСӨНЗҮЙЛ СУМ



ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мөнхбулаг
2024 он

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ

2024.12.25

Мөнхбулаг

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт: Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа газар нэгжийг хамруулсан тоо	Сумын цахим хаягт байршуулдаг	Сургалт сурталчилгааг нэмэгдүүлсэн байна.	Албан байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудсуудаар Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага, шторк, мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна. Мөн http://esunzuil.ov.gov.mn/ веб сайтад мэдээллийг байршуулан ажиллаж байна.	100
1.2. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах.	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	-	Нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Есөнзүйл суманд хамаарах арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

1.3.Байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах.	Цахим хаягуудаар иргэдэд мэдээлэл өгсөн байна.	-	Сар бүр шинэчлэх	Засаг даргын Тамгын газарт Ил тод байдлын самбар байршуулан мэдээллийг тухай бүр шинэчлэн иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн төсвийн ил тод байдлын самар байршуулан мэдээллийг тухай бүр шинэчлэн төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. https://www.facebook.com/esunzuil.zdtgazar гэсэн цахим хаягаар иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. 2023 онд https://shilendans.gov.mn/ сайтад мэдээллийг бүрэн оруулаад байна.	100
1.4. Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сургалт сурталчилгааг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх.	Боловсруулсан материал, бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгийн тоо	100 ш тараах материал	Мэдээллийг тухай бүр сумын цахим хуудсанд байршуулах	Тухайн онд иргэдэд мэдээ, тайланг түргэн шуурхай хүргэх зорилгоор http://esunzuil.ov.gov.mn/ веб сайт болон https://www.facebook.com/esunzuil.zdtgazar , Зар Есөнзүйл сум, https://www.facebook.com/groups/esonzuil Есөнзүйл сумын нэгдсэн групп, Есөнзүйл онцгой комисс гэсэн цахим хаягуудаар мэдээллийг иргэдэд түгээн ажиллаж байна.	100
Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах					
2.1.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх.	Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.	-	Байгууллагын 1 доошгүй үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлнэ.	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: 1. Сумын Засаг даргын Тамгын газрын төсөв болон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулалтад иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан нээлттэй сонсгол хийж иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. 2. Албан тушаалтныг үйл ажиллагаандаа	100

				авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөгөө өгөн болзошгүй тохиолдолд мэдэгдэл тайлбар гаргуулан авч зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна. 3.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдаас урьдчилан мэдүүлгийг авч хууль тогтоомжийн хүрээнд хянуулан албан тушаалт томилж хэвшээд байна. Мөн шинээр томилогдон ажиллаж байгаа албан хаагч бүрд сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил, авлига албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар тухай бүр зөвлөмж өгөн ажиллаж байна. 4.Иргэдийн төлөөлөгчдийн хуралд төсвийн талаарх мэдээллийг 3 удаа оруулан үнэлэлт дүгнэлт аван ажиллаж байна.	
2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.	Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо	-	2 доошгүй арга хэмжээ зохион байгуулах	Албан тушаалтныг үйл ажиллагаандаа авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөгөө өгөн болзошгүй тохиолдолд мэдэгдэл тайлбар гаргуулан авч зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна. Сумын Засаг даргын Тамгын газрын төсөв болон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулалтад иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан нээлттэй сонсгол хийж иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.	100
2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх	Ил тод байршуулж мэдээлсэн мэдээллийн тоо	-	Зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээнд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон олон нийтийг төлөөлөх төлөөлөгчидтэй хамтран хяналт шалгалтыг тухай бүр нь хийж олон нийтэд мэдээлэн ажилласан. Мөн Сумын Засаг даргын Тамгын газрын төсөв болон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулалтад	100

				нээлттэй сонсгол хийж иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд төсвийн талаарх мэдээллийг 3 удаа оруулан үнэлэлт дүгнэлт аван ажиллаж байна.	
2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Дүн шилжилгээ хийсэн мэдээлэл	-	Гомдол мэдээлэл буурсан байна	2024 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 505 өргөдөл хүлээн авч үүнээс 488 өргөдлийг шийдвэрлэн хугацаа болоогүй 17 өргөдлийг шийдвэрлэх шатанд явж байна. 2024 онд өргөдлийг 96,6% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүдийн 97% бичгээр, үлдсэн 3 хувь цахимаар ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг агуулгын хувьд авч үзвэл нийт өргөдөл гомдлын 46,53% буюу 235 өргөдөл нь нийгмийн халамжийн асуудлаар ирүүлсэн өргөдөл, хүсэлт эзэлж байна. Мөн нийгмийн даатгалтай холбоотой өргөдөл 88, газар өмчлөх тухай хүсэлт өвөлжөө хаваржааны газар хүссэн өргөдөл нийт 58, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах талаарх өргөдөл 75, ажилд орох, чөлөөлүүлэхтэй холбоотой өргөдөл 32, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 0, хүлэмж хүссэн 3, Жирэмсний амралт хүссэн 2, чөлөө олгох 2, бусад агуулгаар 9 өргөдөл тус тус ирж шийдвэрлэн ажилласнаас нийт газар хүссэн 17 өргөдлийн хугацаа болоогүй байна.	100
Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох					

3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо	 төрлийн гэрээнд	 доошгүй гэрээнд тусгасан байна	Албан тушаалтныг үйл ажиллагаандаа авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөгөө өгөн болзошгүй тохиолдолд удирдлагын түвшинд захирамж, тушаал гаргах, хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийхэд албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах хууль тогтоомжийн хэрэгжилтийг нь ханган ажиллах үүднээс мэдэгдэл тайлбар гаргуулан авч зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна.	100
3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Сумын Засаг даргын Тамгын газар нь http://esunzuil.ov.gov.mn/ веб сайтыг хөтөлж мэдээллийг тухай бүр баяжуулан иргэдэд мэдээллийг шуурхай хүргэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, хувь хүний мэдээлэл хамгаалах” тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2022 оны “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх” тухай 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг 92,0%-ийн биелэлттэй ханган биелүүлж холбогдох дээд байгууллагад мэдээ тайланг хугацаанд нь хүргэн ажилласан болно. Мөн мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх үүднээс https://www.facebook.com/esunzuil.zdtgazar , Есөнзүйл онцгой комисс, Зар Есөнзүйл сум, Есөнзүйл цаг уур, Есөнзүйл сумын нэгдсэн групп гэсэн цахим хаягуудыг ажиллуулан мэдээллийг тухай бүр	100

				шинэчлэн иргэдэд мэдээ мэдээлэл шуурхай хүргэн ажиллаж байна. Emongolia цахим систем болон иргэдэд шууд хүрч үйлчлэх нийт 95 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар emongolia цахим системээс нийт 294 иргэнд, emongolia операторын үйлчилгээг үзүүлснээс 283 лавлагаа, олон шатлалт 11 үйлчилгээг үзүүлээд байна. Мөн 50 гаруй иргэнд шүүхийн талаарх мэдээ мэдээлэл хүргэж 80 гаруй иргэнд хууль эрх зүйн зөвлөгөөг хүргэж ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 15 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 2000 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 8 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Гэрэгээ Киоск машины үйлчилгээг нийт 300 иргэнд хүргэн ажилласан байна. Төрийн албан хаагч бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын цахим хуудсанд сард 2 удаа эрхэлж байгаа албан ажлын хүрээнд мэдээлэл боловсруулан оруулж байхаар тусган биелэлтийг нь хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж цахим хуудаснуудын баяжилтыг нь тухай бүр хийж иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.	
3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Байгууллагын шударга байдлын үнэлгээ сайжирсан байна.	Байгууллагын даргын тушаалаар албан байгууллага бүрд байгууллагын дотоод хяналтын багийг томилон жил бүр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн	100

				гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар заалт оруулан гүйцэтгэлд нь хагас бүтэн жилээр нь биелэлтийг тооцон зөрчил дутагдалгүй ажиллаж байна.	
3.3.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төсвийн шууд захирагч болон санхүүгийн ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөнд албан хаагчдыг хамруулах.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	250 доошгүй Төсвийн шууд захирагч нарыг хамруулсан байна.	Өвөрхангай аймгийн Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” чиглэлээр төсвийн шууд захирагч болон санхүүгийн ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөнд албан хаагч нарыг бүрэн хамруулан ажилласан.	100
3.4.Байгууллагын шударга байдлыг үнэлгээг ахиулж, иргэдэд үйлчилж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	Албан хаагчдын иргэдэд үзүүлсэн үйлчилгээ	-	-	Албан байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг аван үнэлэлт дүгнэлт өгүүлэн үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Мөн иргэдээс 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын талаар 4 багийн иргэдээс санал асуулга аван үр дүнг нэгтгэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг хэлэлцүүлэн иргэдийн саналыг тусган төлөвлөгөөг баталгаажуулаад байна.	100
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ					100

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА